

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТ

Жимс, жимсгэний чанамал. Техникийн ерөнхий шаардлага	MNS 0462:2023
Fruits jam. General technical requirements	MNS 0462:1977-ийн оронд

Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2023 оны .. дүгээр сарын ..-ны өдрийн .. дугаар тогтоолоор батлав.

Энэхүү стандарт нь 20.. оны .. дүгээр сарын ..-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэ стандартын шаардлагыг заавал мөрдөнө.

1. Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь жимс жимсгэний чанамал үйлдвэрлэх, шалгаж хүлээн авах, савлах, хаяглалт, хадгалах, тээвэрлэхэд хамаарна.

2. Норматив эшлэл

Энэ стандартад Монгол Улсын болон олон улсын дараах стандартыг эш татсан болно. Эш татсан дараах стандартад өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлчийн албан ёсны эх материалаас эш татаж хэрэглэнэ. Үүнд:

- MNS 0462:77, Жимсний чанамал
- MNS 1054:1985, Жимс, жимсгэний джем
- ГОСТ Р 53118:2008, Варенье. Общие технические условия
- PN-A-75100:1994, Przetwory owocowe Dzemy
- CAC 296:2009, Codex standard for jams, jellies and marmalades
- ГОСТ Р 52467:2005, Продукты переработки фруктов, овощей и грибов. Термины и определения
- MNS 4504:2008, Хүнсний бүтээгдэхүүн дэх хүнд металлын зөвшөөрөгдөх хэмжээ
- MNS 6361:2012, Хүнс, малын тэжээл дэх микотоксины үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
- MNS 5868:2008, Хүнсний бүтээгдэхүүн дэх пестицидийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
- MNS 6308:2012, Хүнсний бүтээгдэхүүн дэх бичил биетний аюулгүй байдал болон эрүүл ахуйн шалгуур үзүүлэлтийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ
- Монгол улсын Цөмийн энергийн комиссын тогтоол № 06. 2015.07.28 Хавсралт №1

3. Нэр томьёо, тодорхойлолт

3.1 Жимс, жимсгэний чанамал

Шинэ буюу хөлдөөсөн бүхэл эсвэл хэрчсэн, жимс, жимсгэний зөөлөн эд, нухшийг элсэн чихрийн уусмалд чанаж боловсруулан ариутган савласан өтгөн түрхлэг хэлбэрийн бүтээгдэхүүн

4. Техникийн шаардлага

4.1 Жимс, жимсгэний чанамлыг зохих журмын дагуу баталсан жор, технологийн зааврын дагуу “MNS CAC RCP 2:2014, Нөөшилсөн жимс, ногооны эрүүл ахуйн дадал” стандартын шаардлага хангасан үйлдвэрт аюулгүй ажиллагааны дүрмийг баримтлан үйлдвэрлэнэ.

4.2 Жимс, жимсгэний чанамлыг үйлдвэрлэхэд ашиглах түүхий эд, үндсэн ба туслах материал нь Монгол улсад мөрдөж байгаа стандартын шаардлагыг хангасан байна.

4.3 Жимс, жимсгэний чанамалд “MNS CAC 192:2015, Хүнсний нэмэлт” стандартаар зөвшөөрсөн хүнсний нэмэлтийг хэрэглэж болно.

4.4 Жимс, жимсгэний чанамал нь мэдрэхүйн эрхтний үзүүлэлтээр 1-р хүснэгт, физик-химийн үзүүлэлтээр 2-р хүснэгт, эрүүл ахуй, аюулгүй байдлын үзүүлэлтээр 3-р хүснэгтэд заасан шаардлагыг тус тус хангасан байна.

1-р хүснэгт – Жимс жимсгэний чанамлын мэдрэхүйн үзүүлэлт

Д/д	Үзүүлэлт	Шаардлага
1	Амт	Хэрэглэж байгаа жимс жимсгэний өөр өөрийн өвөрмөц амтыг тод хадгалсан, чихэрлэг буюу исгэлэндүү ¹ , чихэрлэг амттай байна,
2	Үнэр	Гадны ямар нэгэн үнэргүй, тухайн жимс жимсгэний үнэрийг тод хадгалсан байна.
3	Өнгө	Чанамалд хэрэглэж байгаа жимс, жимсгэний ойролцоо ² өнгөтэй байна. Цайвар өнгийн зөөлөн эдтэй /хэсэг/ жимс жимсгэнийх цайвар хүрэн туяатай, бараан өнгийн зөөлөн эдтэй /хэсэг/ жимс жимсгэнийх бор хүрэн туяатай байж болно.
4	Биет байдал	Жимс, түүний зүсэгдсэн хэсэг зөөлөн сайн чанагдсан, хэт чанагдаагүй ба чихрийн талсжилт байж болохгүй. Жимс жимсгэний чанамал нь хэвтээ хавтгай дээр урсахгүй ³ цэлцэн байдалтай байна. Тэнцүү биц хэмжээтэй жимс жимсгэний хуваагдмал хэсэг байж болно.

¹ – Хадны чанамал нь бага зэргийн исгэлэн амттай байхыг зөвшөөрнө.

² – Цайвар өнгийн зөөлөн эдтэй /хэсэг/ жимс, жимсгэний чанамал цайвар хүрэн туяатай, бараан өнгийн зөөлөн эдтэй /хэсэг/ жимс жимсгэний чанамал бор хүрэн туяатай байж болно.

³ – Чавга, интоор, гүзээлзгэний чанамал нь хэвтээ хавтгай дээр бага зэрэг урсамтгай байж болно.

2-р хүснэгт – Жимс жимсгэний чанамлын физик химийн үзүүлэлт

Д/д	Үзүүлэлт	Шаардлага				
		Хадны чанамал	Чавганы чанамал	Интоорын чанамал	Гүзээлзгэний чанамал	Олон жимсний чанамал

1	Хуурай бодис % Багагүй	45	40			
2	Хүчиллэг %	1,2-1,5	0,5-0,8	0,4-0,6	0,4-0,6	0,6-0,8
3	Чихэрлэг % багагүй	40			30	40

3-р хүснэгт – Жимс жимсгэний чанамлын эрүүл ахуй, аюулгүй байдлын үзүүлэлт

Д/д	Үзүүлэлт	Шаардлага
1	Хүнсний бүтээгдэхүүн дэх бичил биетний аюулгүй байдал болон эрүүл ахуйн шалгуур үзүүлэлтийн зөвшөөрөгдөх хэмжээ	MNS 6308:2012
2	Пестицидийн үлдэгдэл, мг/кг	MNS 5668:2008
3	Хүнд металл	MNS 4504:2008
4	Цацраг илэвхит бодис	Монгол улс Цөмийн энергийн комиссын 2015.07.28-ны өдрийн 06-р тогтоол
5	Афлатоксин, мкг/кг, ихгүй	≤4

5. Шалгаж хүлээж авах

5.1 Жимс жимсгэний чанамалыг дараах стандартын дагуу шалгаж хүлээн авна.

Үүнд:

MNS 0344:88 Чихэр боовон бүтээгдэхүүн: Чихэрлэг тодорхойлох арга

MNS ISO 750:2000 Жимс ба ногооны бүтээгдэхүүн-Титрлэгдэх хүчиллэг тодорхойлох

MNS 0343:84 Чихэр боовон бүтээгдэхүүн: Чийглэг хуурай бодис тодорхойлох аргууд

MNS 0382:61 Чихэр боовон бүтээгдэхүүн:

MNS ISO 4833:95 Микробиологи. 30°C –т бичил биетний колони тоолох ерөнхий арга

MNS ISO 4834:99 Колиформын тоог тогтоох Колони тоолох арга

MNS 5132:2002 Хүнсний бүтээгдэхүүн. Мөөгөнцрийг таньж тодорхойлох арга

MNS ISO 6888-1: 2011 Хүнс ба малын тэжээлийн микробиологи. Сийвэн бүлэгнүүлэгч стабликоккын тоог тогтоох 1-р хэсэг

MNS ISO 6888-2:2011 Хүнс ба малын тэжээлийн микробиологи. Сийвэн бүлэгнүүлэгч стабликоккын тоог тогтоох 2-р хэсэг

MNS 4496:1997 Хүнсний бүтээгдэхүүнд хар тугалгын агуулгыг тодорхойлох атом шингээлтийн спектрометрийн арга.

MNS 5626:2006 Цацрагийн хамгаалалт. Лабораторийн гаммаспектрометрийн арга

MNS 5692:2006 Ургамлын гаралтай хүнсний бүтээгдэхүүнд Микотоксин-Патулиныг тодорхойлох Нимгэн үет хроматографын арга

MNS 5549:2005, Хүнсний бүтээгдэхүүнд афлатоксин В1, В2, G1, G2–ийн агууламжийг тодорхойлох нимгэн үеийн хроматографийн арга

MNS 4833:99, Хүнсний бүтээгдэхүүнд хлорорганик пестицид тодорхойлох нимгэн үет хроматографийн арга

MNS 4832:99, Хүнсний бүтээгдэхүүнд фосфорорганик пестицид тодорхойлох нимгэн үет хроматографийн арга

5.2 Шинжилгээг 2-оос доошгүй удаагийн давтамжтай гүйцэтгэж, зэрэгцээ гарган авсан үр дүнгийн дунджаар илэрхийлнэ.

6. Савлах, шошголох

6.1 Жимс жимсгэний чанамлыг 0,3-0,5 кг хүртэл жинтэйгээр стандартын шаардлага хангасан хүнсний зориулалтын шилэн ба хуванцар саванд савлана.

6.2 Савласан бүтээгдэхүүний жингийн хэлбэлзэл $\pm 1\%$ -иас ихгүй байна.

6.3 Савласан жимс, жимсгэний чанамал нь MNS CAC 1:2007 Савласан хүнсний бүтээгдэхүүний шошгололтод тавих ерөнхий шаардлага хангасан шошготой байна.

7. Хадгалах, тээвэрлэх

7.1 Савлаж ариутгасан жимс, жимсгэний чанамлыг нарны гэрлийн шууд тусгалаас хамгаалсан, агаарын харьцангуй чийглэг нь 70%-иас ихгүй, 0-20 С⁰ – ийн температуртай ариун цэвэр эрүүл ахуйн шаардлага хангасан нөхцөлд 18 сар хүртэл хугацаагаар хадгална.

7.2 Савлаж ариутгасан жимс, жимсгэний чанамлыг хүнсний бүтээгдэхүүн тээвэрлэх зориулалт бүхий тээврийн хэрэгслээр тээвэрлэнэ.

ТӨГСӨВ